



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.26 № ЗГ-1/56  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002320



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.25 № ХЖ/1813

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт  хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



 Б.ЭНХБАЯР


000265006630

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“11.ХЭЛЭЛЦСЭН нь: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.22 № 1/2709

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5

152641011



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>


2026.05.22 № 01/5896

танай 2026.05.21-ны № 1/2705-т

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД С.АМАРСАЙХАН ТАНАА**

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан холбогдох хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,



С.МЭНДСАЙХАН

9761000889



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33.

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.05.22 № 1/2710

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА**


Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох хууль тогтоомжийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 19<sup>1</sup>.1. дэх хэсэгт зааснаар Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг хангасан байна.



С.АМАРСАЙХАН

ХЗДХЯ-ны А5

152641010



БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ЭНХБАЯР

2026 оны 06 дугаар сарын 14-ны өдөр

**ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ  
ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ” гэж заасан.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг зохицуулахаар тусгасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулах бөгөөд хуулийн дагаж мөрдөх хугацааг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр тогтоосон байсан.

Тус хуулийг батлахтай зэрэгцүүлэн “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолоор Дархан, Эрдэнэт, Зуунмод, Хархорум, Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн

зэрэглэлтэй 43 (үүнээс 14 нь нийслэлд), дагуул 4 (үүнээс 3 нь нийслэлд) хотыг тус тус байгуулахаар шийдвэрлэсэн.

Түүнчлэн, хот байгуулсантай холбогдуулан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, тэдгээрээс нэр дэвшүүлж томилогдсон Засаг дарга нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл харьяалах хотын Зөвлөл, Захирагчийн хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад тодорхой хугацаа шаардлагатай байсныг харгалзан Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулж, тус хуулийг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хойшлуулсан.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын хот, суурин газрын хөгжлийг зөвхөн засаг захиргааны зохион байгуулалтын хүрээнд бус, улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засаг, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний төв болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой.

Өөрөөр хэлбэл, энэ хууль нь бүс нутгийн хөгжлийг зөвхөн аймаг, сумын төвийн түвшинд хязгаарлахгүйгээр тухайн бүс нутгийн таталцлын төв, хүн амын төвлөрөл, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, тээвэр логистик, инженерийн дэд бүтцийн зангилаа болгон хөгжүүлэх боломжийг нээх юм. Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, хөрөнгө оруулалт тодорхой төвүүдэд чиглэж, бүс нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах, орон нутаг амьдрах, ажиллах, хөрөнгө оруулах нөхцөлийг сайжруулах төрийн бодлогын чухал суурь бүрдэх юм.

Засгийн газраас боловсруулсан энэхүү хуулийн төслийн зорилго нь хот байгуулах бодлогыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бодит тооцоо, судалгаанд суурилсан, эрх зүйн болон зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжтой үе шаттай арга хэлбэрээр хэрэгжүүлэхэд оршино. Хот байгуулах асуудал нь зөвхөн нэршил, статусын асуудал бус, тухайн хотын эдэлбэр газар, хил зааг, удирдлагын бүтэц, чиг үүрэг, төсөв, өмч хөрөнгө, хүний нөөц, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний зохион байгуулалттай шууд холбоотой цогц асуудал юм.

Энэ хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад дараах хүндрэл бэрхшээлүүд үүсэж байна.

Хот байгуулахад хүн амын тоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, дэд бүтэц, зам харилцаа, инженерийн байгууламж, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үзүүлэх нөлөөлөл зэрэг олон шалгуурыг хамтад нь тооцох шаардлагатай. Гэвч өмнө батлагдсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх явцад зарим хотын хүн амын тоо, эдэлбэр газар, хил зааг, өмч, төсөв, байгууллагын бүтэц бүрэн тодорхой болоогүй байна. Ийм нөхцөлд улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул

хотуудыг нэгэн зэрэг байгуулах нь чиг үүргийн давхардал, төсвийн нэмэлт ачаалал, зохион байгуулалтын хүндрэл үүсгэх эрсдэлтэй тул хот байгуулах бодлогыг бодит нөхцөл, бэлтгэл ажлын түвшинтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Иймд дээр дурдсан практик хүндрэл, бэрхшээл, нөхцөл шаардлагыг харгалзан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан хуулийн төсөлд хот байгуулах бодлогыг эрх зүй, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн хувьд бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах гол зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

1.Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 2 хотын зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв, санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг ханган хэрэгжүүлэхээр тусгасан. Харин орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын асуудлыг дээрх хотуудын хэрэгжилтийн явц, үр дүн, туршлага, гарсан хүндрэл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замд үндэслэн дараагийн шатанд үе шаттайгаар шийдвэрлэхээр тооцож байна. Энэ зорилгоор “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хот байгуулахтай холбоотой холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

2.Чиг үүргийн давхардал, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр шинэ бүтэц шууд давхардан бий болохоос сэргийлж, төрийн үйлчилгээ тасалдахгүй байх, төсвийн нэмэлт ачааллыг бууруулах, хотын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулснаар дараах нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар гарна гэж үзэж байна:

-Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд хот байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг бодитоор хангах цаг хугацааны боломж бүрдэнэ;

-хотын шалгуур бодитой болж, тооцоо, судалгаагүйгээр хот байгуулах эрсдэл арилна;

-хот байгуулах асуудлыг засаг, захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан цогцоор шийдвэрлэх хууль зүйн боломж, хувилбарыг судлан боловсруулах, эдийн засаг, нийгэм, хууль зүйн үндэслэлтэйгээр үе шаттай хэрэгжүүлэх боломжит хугацаа бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---o0o---

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоор улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 43, дагуул 4 хотыг байгуулах шийдвэр гарсан.

Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан Улсын Их Хурлаас 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаагаар хойшлуулсан байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын хот, суурин газрын хөгжлийг зөвхөн засаг захиргааны зохион байгуулалтын хүрээнд бус, улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засаг, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний төв болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой.

Өөрөөр хэлбэл, энэ хууль нь бүс нутгийн хөгжлийг зөвхөн аймаг, сумын төвийн түвшинд хязгаарлахгүйгээр тухайн бүс нутгийн таталцлын төв, хүн амын төвлөрөл, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, тээвэр логистик, инженерийн дэд бүтцийн зангилаа болгон хөгжүүлэх боломжийг нээх юм. Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, хөрөнгө оруулалт тодорхой төвүүдэд чиглэж, бүс нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах, орон нутагт амьдрах, ажиллах, хөрөнгө оруулах нөхцөлийг сайжруулах төрийн бодлогын чухал суурь бүрдэх юм.

Энэ хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад дараах хүндрэл бэрхшээлүүд үүсэж байна.

Хот байгуулахад хүн амын тоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, дэд бүтэц, зам харилцаа, инженерийн байгууламж, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үзүүлэх нөлөөлөл зэрэг олон шалгуурыг хамтад нь тооцох шаардлагатай. Гэвч өмнө батлагдсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх явцад зарим хотын хүн амын тоо, эдэлбэр газар, хил зааг, өмч, төсөв, байгууллагын бүтэц бүрэн тодорхой болоогүй байна. Ийм нөхцөлд улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудыг нэгэн зэрэг байгуулах нь чиг үүргийн давхардал, төсвийн нэмэлт ачаалал, зохион байгуулалтын хүндрэл үүсгэх эрсдэлтэй тул хот байгуулах бодлогыг бодит нөхцөл, бэлтгэл ажлын түвшинтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Иймд дээр дурдсан практик хүндрэл, бэрхшээл, нөхцөл шаардлагыг харгалзан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Дээр дурдсан хүндрэл, бэрхшээл, нөхцөл байдлыг харгалзан хуулийн төсөлд хот байгуулах бодлогыг эрх зүй, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн хувьд бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах гол зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

1.Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 2 хотын зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв, санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг ханган хэрэгжүүлэхээр тусгасан. Харин орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын асуудлыг дээрх хотуудын хэрэгжилтийн явц, үр дүн, туршлага, гарсан хүндрэл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замд үндэслэн дараагийн шатанд үе шаттайгаар шийдвэрлэхээр тооцож байна. Энэ зорилгоор “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хот байгуулахтай холбоотой холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

2.Чиг үүргийн давхардал, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр шинэ бүтэц шууд давхардан бий болохоос сэргийлж, төрийн үйлчилгээ тасалдахгүй байх, төсвийн нэмэлт ачааллыг бууруулах, хотын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хот байгуулах бодлогыг үе шаттай, хэрэгжих боломжтой, санхүү, төсөв, зохион байгуулалтын бэлтгэлтэй уялдуулан хэрэгжүүлэх нь улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, бүс нутгийн эдийн засгийн төвүүдийг зөв төлөвшүүлэх, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бий болгох, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, дотоодын зах зээл, тээвэр логистик, дэд бүтцийн уялдааг сайжруулах ач холбогдолтой. Энэ нь эдийн засгийн нөөцийг зөв хуваарилах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой, урьдчилан тооцоолох боломжтой эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогын зорилттой шууд холбогдож байна.

Түүнчлэн хот байгуулахтай холбоотой эрх зүй, төсөв, зохион байгуулалтын тодорхойгүй байдал удаан үргэлжилбэл хөрөнгө оруулалтын шийдвэр хойшлох, орон нутгийн хөгжлийн бодлого хэрэгжихгүй удаашрах, төсвийн хөрөнгө оруулалт давхцах буюу үр ашиггүй зарцуулагдах, төрийн үйлчилгээний тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй. Иймээс уг асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх нь эдийн засгийн өсөлтийн суурийг бүс нутагт тэнцвэртэй бүрдүүлэх, хөгжлийн бодлогын залгамж чанарыг хангах, төсөв, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх замаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Иймд уг хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан журмын дагуу яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Хуулийн төсөлтэй холбогдуулан “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар

тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---oOo---

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталж, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоор улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 43, дагуул 4 хотыг байгуулах шийдвэр гарсан.

Дээрх хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан Улсын Их Хурлаас 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаагаар хойшлуулсан байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын хот, суурин газрын хөгжлийг зөвхөн засаг захиргааны зохион байгуулалтын хүрээнд бус, улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засаг, дэд бүтэц, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, үйлчилгээний төв болгон хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой.

Өөрөөр хэлбэл, энэ хууль нь бүс нутгийн хөгжлийг зөвхөн аймаг, сумын төвийн түвшинд хязгаарлахгүйгээр тухайн бүс нутгийн таталцлын төв, хүн амын төвлөрөл, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, тээвэр логистик, инженерийн дэд бүтцийн зангилаа болгон хөгжүүлэх боломжийг нээх юм. Ингэснээр төрийн үйлчилгээ иргэдэд ойртож, хөрөнгө оруулалт тодорхой төвүүдэд чиглэж, бүс нутгийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэх, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах, орон нутагт амьдрах, ажиллах, хөрөнгө оруулах нөхцөлийг сайжруулах төрийн бодлогын чухал суурь бүрдэх юм.

Засгийн газраас боловсруулсан энэхүү хуулийн төслийн зорилго нь хот байгуулах бодлогыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, бодит тооцоо, судалгаанд суурилсан, эрх зүйн болон зохион байгуулалтын хувьд хэрэгжих боломжтой үе шаттай арга хэлбэрээр хэрэгжүүлэхэд оршино.

Хот байгуулах асуудал нь зөвхөн нэршил, статусын асуудал бус, тухайн хотын эдэлбэр газар, хил зааг, удирдлагын бүтэц, чиг үүрэг, төсөв, өмч хөрөнгө, хүний нөөц, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний зохион байгуулалттай шууд холбоотой цогц асуудал юм.

Энэ хүрээнд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад дараах хүндрэл бэрхшээлүүд үүсэж байна:

Хот байгуулахад хүн амын тоо, эдийн засаг, нийгмийн ач холбогдол, дэд бүтэц, зам харилцаа, инженерийн байгууламж, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид үзүүлэх нөлөөлөл зэрэг олон шалгуурыг хамтад нь тооцох шаардлагатай. Гэвч өмнө батлагдсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх явцад зарим хотын хүн амын тоо, эдэлбэр газар, хил зааг, өмч, төсөв, байгууллагын бүтэц бүрэн тодорхой болоогүй байна. Ийм нөхцөлд улсын зэрэглэлтэй, орон нутгийн

зэрэглэлтэй болон дагуул хотуудыг нэгэн зэрэг байгуулах нь чиг үүргийн давхардал, төсвийн нэмэлт ачаалал, зохион байгуулалтын хүндрэл үүсгэх эрсдэлтэй тул хот байгуулах бодлогыг бодит нөхцөл, бэлтгэл ажлын түвшинтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Иймд дээр дурдсан практик хүндрэл, бэрхшээл, нөхцөл шаардлагыг харгалзан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүсэж байна.

Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор байгуулсан хотуудаас 2025 оны жилийн эцсийн хүн амын тоогоор шалгуур хангаагүй дараах хотууд байна:

1. Улсын зэрэглэлтэй хотуудаас 100,000 доошгүй байнгын оршин суугчтай байх шалгуур хангасан зөвхөн Эрдэнэт (103,1 мянга) хот байна. Харин Зуун мод (17,5 мян), Багануур (32,4 мян), Налайх (38.6 мян), Дархан (88,7 мян), Шинэ Хархорин буюу нийт 6-хотоос 5 буюу 83,3% нь энэ шалгуурыг хангаагүй байна.

2. Орон нутгийн зэрэглэлтэй хотуудаас (*одоогоор оршин суугчид нь тодорхойгүй Агро Сити хотыг оруулахгүй тооцвол*) 30,000 доошгүй байнгын оршин суугчтай байх шаардлага хангаагүй: Цэцэрлэг хот (20.3 мян), Булган хот (15.3 мян), Алтай хот (18.6), Чойр хот (18.02), Замын-Үүд хот (18.3), Мандалговь хот (13.6), Улиастай хот (15.9), Тосонцэнгэл хот (9.4), Хархорин хот (11.9), Ханбогд хот (9.5), Цогтцэций хот (10.5), Баруун-Урт хот (21.5), Хөтөл хот (9.1), Мандал хот (26.4), Байтаг богд хот (10.1), Хатгал хот (3.6), Чингис хот (28.4), Бор-Өндөр хот (8.9), Бэрх хот (2.2), Багахангай дагуул хот (4.1), Шарын гол дагуул хот (7.2) буюу нийт 44 хотоос 20 нь буюу 54.5% нь шаардлага хангахгүй байна.

Хотуудыг шинээр байгуулсантай холбогдуулан улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, дагуул хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох, харьяалах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмч, хөрөнгө, төсөв, байгууллагын бүтэц, орон тоог чиг үүрэг нь шилжиж байгаа хотод хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх асуудлаар тухайн орон нутгийн байгууллагуудтай зайлшгүй зөвшилцөх шаардлага үүсээд байгаа боловч асуудлын шийдэл бүрэн тодорхой болоогүй, холбогдох ажлыг зохион байгуулахад хугацаа шаардагдах нөхцөл байдал хэвээр байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2024 оны “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг дээр дурдсан бөгөөд асуудлыг хууль, эрх зүйн хувьд бүрэн шийдэх хугацаа хэрэгтэй байна гэж үзлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 93 дугаар захирамжаар Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д, “Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх талаар холбогдуулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгээс улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудыг нэгэн зэрэг байгуулах нь чиг үүргийн давхардал, төсвийн нэмэлт ачаалал, зохион байгуулалтын хүндрэл үүсгэх эрсдэлтэй тул хот байгуулах бодлогыг бодит нөхцөл, бэлтгэл ажлын түвшинтэй уялдуулан үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг

дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

Дээр дурдсан хүндрэл, бэрхшээл, нөхцөл байдлыг харгалзан хуулийн төсөлд хот байгуулах бодлогыг эрх зүй, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн хувьд бодитой хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах гол зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа:

1.Багануур, Налайх гэсэн улсын зэрэглэлтэй 2 хотын зохион байгуулалт, эдэлбэр газар, хил зааг, чиг үүргийн шилжилт, төсөв, санхүү, хүний нөөцийн бэлтгэлийг ханган хэрэгжүүлэхээр тусгасан. Харин орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын асуудлыг дээрх хотуудын хэрэгжилтийн явц, үр дүн, туршлага, гарсан хүндрэл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замд үндэслэн дараагийн шатанд үе шаттайгаар шийдвэрлэхээр тооцож байна. Энэ зорилгоор “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 72 дугаар тогтоолын улсын болон орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хот байгуулахтай холбоотой холбогдох зохицуулалтыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

2.Чиг үүргийн давхардал, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох зорилгоор шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. Тодруулбал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл хугацаанд тухайн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга нь хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Ингэснээр шинэ бүтэц шууд давхардан бий болохоос сэргийлж, төрийн үйлчилгээ тасалдахгүй байх, төсвийн нэмэлт ачааллыг бууруулах, хотын удирдлагын тогтолцоог үе шаттай бүрдүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх хэрэгцээ, шаардлагын тухайд:

Хот байгуулах бодлогыг үе шаттайгаар санхүү, төсөв, зохион байгуулалтын бэлтгэлтэй уялдуулан хэрэгжүүлэх нь бүс нутгийн эдийн засгийн төвүүдийг төлөвлөн хөгжүүлэх, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байр, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг бий болгох, Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, дотоодын зах зээл, тээвэр логистик, дэд бүтцийн уялдааг сайжруулах ач холбогдолтой юм.

Энэ нь эдийн засгийн нөөцийг зөв, оновчтой хуваарилах, бүс нутгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын тогтвортой, урьдчилан тооцоолох боломжтой эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар эдийн засгийн хэт төвлөрлөөс үүдэх эрсдэлийг бууруулж, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлогын зорилттой нийцэж байна.

Түүнчлэн, хот байгуулахтай холбоотой эрх зүй, төсөв, зохион байгуулалтын зохицуулалтын тодорхойгүй байдал хэвээр үргэлжилбэл хөрөнгө оруулалтын шийдвэр хойшлох, орон нутгийн хөгжлийн бодлогын хэрэгжилт удаашрах, төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй зарцуулагдах, төрийн үйлчилгээний тогтвортой байдал алдагдах эрсдэл үүсгэхээр байна.

Иймд эрх зүйн зохицуулалтыг шуурхай бүрдүүлж, бүчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилт, төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн уялдааг

хангах зорилгоор уг хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр өргөх мэдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан “Хот байгуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөрУлаанбаатар  
хотХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1 дүгээр зүйл. Хуульд өөрөөр заагаагүй бол улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл дараах байдлаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хэрэгжүүлнэ.”

| Д/д                          | Хотын нэр    | Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага | Хотын удирдлага         |
|------------------------------|--------------|--|-------------------------|
| <b>Улсын зэрэглэлтэй хот</b> |              |  |                         |
| 1                            | Багануур хот | Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  | Багануур хотын Зөвлөл   |
|                              |              | Нийслэлийн Багануур дүүргийн Засаг дарга   | Багануур хотын Захирагч |
| 2                            | Налайх хот   | Нийслэлийн Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  | Налайх хотын Зөвлөл     |
|                              |              | Нийслэлийн Налайх дүүргийн Засаг дарга   | Налайх хотын Захирагч   |

**2 дугаар зүйл.** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2, 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар  
хот

**ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Хот байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 72 дугаар тогтоолын 11 дэх заалтын 1 дэх дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1/улсын зэрэглэлтэй хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоох асуудлаар Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх;”

2.Мөн тогтоолын 1 дэх заалтын хүснэгтийн “Нэг.Улсын зэрэглэлтэй хот” гэсэн хэсгийн 1, 2, 3 дахь мөр, “Хоёр.Орон нутгийн зэрэглэлтэй хот”, “Гурав.Дагуул хот” гэсэн хэсгийг тус тус хассугай.

3.Мөн тогтоолын 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**



ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

---

Хот, тосгоны эрх зүйн байдлын  
тухай хуулийг дагаж мөрдөх  
журмын тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төслийн  
зардлын тооцоо

---



2026 он

**Судалгааг захиалагч:**

Хууль зүй, дотоод хэргийн яам

**Судалгааг хянасан:**  
М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
Хууль зүйн доктор

**Судалгааг гүйцэтгэсэн:**

М.Ганди

Эрдэм шинжилгээний ажилтан

З.Мөнгөлжин

Эрдэм шинжилгээний ажилтан

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ХТЭЗБтХ

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль

ЗГ

Засгийн газар

ХТЭЗБТХНӨОтХ

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хууль

## АГУУЛГА

|  |   |
|--|---|
| I. УДИРТГАЛ                            | 5 |
| II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО | 7 |
| III. ДҮГНЭЛТ, САНАЛ                    | 9 |

## I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаартай “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдох арга хэмжээний тухай” тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-т хот, тосгоны эрх зүйн үндсийг тодорхой болгож, тэдгээрийн өөрийн удирдлага, өмчийн болон төсвийн зохицуулалтыг нарийвчлан тусгах, хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг зохицуулахаар тусгасны дагуу Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсан байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-иар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээрийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуур, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулах бөгөөд хуулийн дагаж мөрдөх хугацааг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөр тогтоосон байсан.

Дээрх хууль, Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах явцад бодит хүндрэл, бэрхшээл тулгарсан тул Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг бодит нөхцөл байдалтай уялдуулах, хот байгуулах болон чиг үүрэг шилжүүлэх асуудлыг судалгаа, тооцоонд үндэслэн үе шаттай хэрэгжүүлэх, төрийн захиргааны давхардлыг арилгах, хуулийн хэрэгжилтийг хангах бэлтгэл ажлыг цогцоор нь бүрдүүлэх зорилгоор Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болсон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцов.

**Судалгааны зорилго.** Аргачлалын 1.4.2-т заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль /цаашид ХТЭЗБТХНӨОтХ гэх/ батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож тэдгээр субъектэд ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарын талаар санал боловсруулах буюу зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

Аргачлалд заасны дагуу төрийн байгууллагын зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээнд, хуулийн этгээдийн зардлыг хууль тогтоомжоор төрийн байгууллагаас бусад аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах мөнгөн зардалд, иргэнд үүсэх зардлыг хууль

тогтоомжоор иргэнд хүлээлгэж байгаа үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан зарцуулах цаг хугацаанд тус тус үндэслэн тооцохоор заасан. Иймд зардлын тооцоог гаргахдаа дараах нийтлэг зарчмыг баримтлав. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Хуулийн төслөөс иргэн, хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлохдоо шинээр буюу өмнө нь гүйцэтгэж байгаагүй үүрэг болон өмнө гүйцэтгэж байсан боловч тухайн үүргийг хуулийн төслөөр өргөжүүлсэн байвал тэр хүрээнд хязгаарлан зардал тээгч этгээдийн зардлыг тооцох болно. Өөрөөр хэлбэл, хуулийн төслөөр зөвхөн шинээр бий болж байгаа үүрэг эсхүл өмнө нь хэрэгжүүлж байсан үүргийн өргөжүүлсэн хэсэгт зардал тооцно.

## II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1. Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
2. Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
3. Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Гүйцэтгэх үүрэг гэдэгт хуулийн төслөөр төрийн холбогдох байгууллагад даалгасан бүртгэл хийх, зөвшөөрөл олгох зэрэг төрийн байгууллагаас үзүүлж буй ажил үйлчилгээг ойлгох ба төрийн байгууллагын үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
- Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
- Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Энэ хэсэгт төслийн зохицуулалтыг уншиж судлах замаар тодорхой үүрэг хүлээж буй төрийн байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар чиг үүрэг буюу ажил үйлчилгээ шинээр гүйцэтгэх эсхүл одоо гүйцэтгэж байгаа чиг үүрэг, ажил үйлчилгээ нь хуулийн төслийн дагуу өргөжсөн эсэхийг тогтоох юм.

2026 оны 06 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх ХТЭЗБТХ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгон, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн үндэс, удирдлагын үйл ажиллагааны зарчим, тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлж, хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон аж ахуйн нэгж, байгууллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулах зорилт бүхий 8 бүлэгтэй.

ХТЭЗБТХНӨТХ-ийн төсөлд дараах зүйл, заалтыг нэмэхээр тусгажээ. Үүнд:

- **1 дүгээр зүйл.** Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“Хуульд өөрөөр заагаагүй бол улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хотын Зөвлөл, Захирагч хуулийн дагуу сонгогдох хүртэл дараах байдлаар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга хэрэгжүүлнэ.”

| Д/д                          | Хотын нэр    | Хотын Зөвлөл, Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага | Хотын удирдлага       |
|------------------------------|--------------|--|-----------------------|
| <b>Улсын зэрэглэлтэй хот</b> |              |  |                       |
| 1                            | Багануур хот | Нийслэлийн Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал  | Багануур хотын Зөвлөл |

|   |            |   |                         |
|---|------------|---|-------------------------|
|   |            | Нийслэлийн Багануур дүүргийн Засаг дарга                | Багануур хотын Захирагч |
| 2 | Налайх хот | Нийслэлийн Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | Налайх хотын Зөвлөл     |
|   |            | Нийслэлийн Налайх дүүргийн Засаг дарга                  | Налайх хотын Захирагч   |

- **2 дугаар зүйл.**Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2, 3 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.
- **3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2026 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Аргачлалын 3.2-т заасны дагуу хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдолтой болон ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой зохицуулалтуудыг хуулийн төслийн дээрх нэмэлт, өөрчлөлтөөс тодорхойлж үзэхэд тус зохицуулалт нь шинээр ажлын байр, орон тоо бий болгохгүй, тогтмол зардал үүсгэхгүй тул төрийн байгууллагад зардал үүсэхгүй байна.

Иймд Аргачлалын 4.4.6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан шийдвэр гаргахад төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоо хийхэд оруулахгүй гэж заасан тул дээрх зохицуулалтууд нь зардлын тооцоонд орохгүй болно.

### III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрд учрах зардлыг урьдчилан тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

ХТЭЗБТХНӨТХ-ийн төслийн 1 дүгээр зүйлд улсын зэрэглэлтэй Багануур болон Налайх хотын Зөвлөл, Захирагч 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хуулийн дагуу сонгогдох хүртэлх шилжилтийн хугацаанд тухайн хотуудын чиг үүргийг одоо байгаа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг дарга хэрэгжүүлэхээр тодорхойлсон зохицуулалт, 2 дүгээр зүйлд дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2, 3 дүгээр зүйлийг хүчингүй болгох зохицуулалтыг тус тус тусгасан байна. Эдгээр зохицуулалт нь шинээр ажлын байр, орон тоо бий болгохгүй тул Аргачлалын 4.4.6-д заасны дагуу зардлын тооцоонд оруулаагүй болно.

Иймд ХТЭЗБТХНӨТХ-ийн төсөлд шинээр ажлын байр, орон тоо бий болгох, тогтмол зардал гаргах зохицуулалт байхгүй тул иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсэхгүй байна.

## НОМ ЗҮЙ

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, 2024 он;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2026 он.
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
- Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоор
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”;

## АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС

|         |                 |   |
|---------|-----------------|---|
| Ахлагч: | -С.Амарсайхан   | -Монгол Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд.                         |
| Гишүүд  | -У.Бямбасүрэн   | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга;  |
|         | -П.Зоригтбаатар | -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга; |
|         | -Б.Батбямба     | -Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч;                       |
|         | -Г.Эрдэнэбулган | -Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга.                      |
|         | -А.Энхманлай    | -Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга;                     |
|         | -М.Санжаадорж   | -Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;                              |
|         | -М.Үнэнбат      | -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга;    |
|         | -С.Даваасүрэн   | -Багануур дүүргийн Засаг дарга;   |
|         | -Д.Наянбаяр     | -Налайх дүүргийн Засаг дарга.   |

---oOo---